



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№69 /513/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.04.27

Цаг үе, үйл явдал

БРИГАДЫН ГЕНЕРАЛ Г.БОЛОР СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗДТГ-ЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНД “УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ БА НӨЛӨӨЛӨЛ” СЭДВЭЭР ЛЕКЦ СОНОРДУУЛЛАА



Монгол улсад генерал цол үүссэний 79 жилийн ойг тохиолдуулан анхны эмэгтэй генерал ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болорыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ, цэргийн штаб хамтран хүлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд АНУ-ын Цагаан ордноос олгодог Олон улсын эмэгтэйчүүдийн эр зоригийн шагналын эзэн болсон бригадын генерал Г.Болорт

нийт бие бүрэлдэхүүн баяр хүргэж хүндэтгэл үзүүллээ.

Үргэлжлүүлэн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ийн нийт алба хаагчдад зориулж бригадын генерал Г.Болор “Удирдлагын манлайлал ба нөлөөлөл” сэдвээр лекц уншсан юм.

Бригадын генерал Г.Болор уулзалт хийх үеэрээ өөрийн амьдралын замналын талаар товч танилцуулга хийсний зэрэгцээ манлайлагч хүнд

байх чадвар, зан чанар, төлөвшил, мэдрэмжтэй, соёлч боловсон, хичээл зүтгэлтэй мэргэжилтэн байхын тулд хувь хүний аливаад хандах хандлага их чухал гэдгийг онцолж байв. Түүнчлэн залуусыг бие биеэсээ суралцаж, үзэл бодлоо чөлөөтэй солилцон, харилцан хүндэтгэж нэгэндээ эергээр нөлөөлөх нь зүйтэй гэдгийг хэлж байсан юм.

Дэслэгч
Б.ЭРДЭНЭБАТ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН АЖИЛТНЫ ТАНГАРАГ ӨРГӨВ



Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагууд сар бүрийн сүүлийн долоо хоногт Цэргийн тангараг давтах ажиллагааг зохион байгуулж, тухайн сард хэрэгжүүлсэн ажлынхаа үр дүнг бие бүрэлдэхүүндээ танилцуулж, ирэх сарын зорилт, үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлдог.

Энэ удаа Зэвсэгт хүчний Жанжин штаб, Тусгай хүчний болон Кибер аюулгүй байдлын цэргийн командлалуудын бие бүрэлдэхүүн 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр ээлжит Цэргийн тангараг давтах ажиллагаагаа зохион байгуулав.

Цэргийн тангараг давтах ёслолын ажиллагааг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр удирдан зохион байгуулсан юм. Энэ үеэр Зэвсэгт хүчний Жанжин штабт шинээр томилогдон ажиллаж буй албан тушаалтнууд ЗХЖШ-ын ажилтны тангараг өргөж, энгэрийн тэмдгээ гардан авлаа.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ...



Зэвсэгт хүчний Хуурай замын нэгтгэл, ангиудаас алба хаагчдынхаа ажиллах орчин нөхцөлийг шинэчлэх сайжруулах хүрээнд энэ жил орон нутгаасаа дэмжлэг авч чадсан нь Зэвсэгт хүчний 167, 186, 326 дугаар ангиуд. Зэвсэгт хүчний 167 дугаар ангийнхан түүхт 50 жилийн ойгоороо Өмнөговь аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар 250 хүний багтаамжтай хоёр давхар бүхий цэргийн гал тогооны барилга болон агааржуулалт, цэвэр, бохир усыг нь шийдвэрлэсэн орчин үеийн бие засах газрыг барьж, Даланзадгад сумын хөрөнгө оруулалтаар шалган нэвтрүүлэх байраа шинэчлэн засварлаж байна. Цэргийн гал тогооны барилгыг Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн барилгачин дайчид барьж байгаа бөгөөд бүтээн байгуулалтууд наадмаас өмнө ашиглалтад орох ажээ. Үүний зэрэгцээ тус ангийнхан түүхт ойдоо зориулж өөрсдийн нөөц бололцоогоор цэргийн байр, эмнэлгээ

шинэчлэн засварлаж, спорт төвийнхөө дулаан болон гадна өнгө үзэмжийг сэргээн сайжруулж, хугацаат цэргийн алба хаагчдын усанд орох газрыг стандарт шаардлагад нь нийцүүлэхээр ажиллаж эхэлжээ.

Зэвсэгт хүчний 186 дугаар ангийнхны хувьд Орхон аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар барилга байгууламж, объектуудынхаа дулааны шугамыг бүрэн шинэчилж, офицер, ахлагчийн цайны газрыг сэргээн сайжруулахаар дэмжлэг авч, орон нутгаас холбогдох тендерүүдийг нь зарлаад байна.

Зэвсэгт хүчний 326 дугаар ангид нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-аас өнгөрсөн гуравдугаар сард зинетчин дайчдын бэлэн байдлыг дээшлүүлэх, гэнэтийн гамшиг ослоос урьдчилан сэргийлэх хүрээнд 50 гаруй сая төгрөгийн үнэ бүхий цэргийн зориулалттай 16 иж бүрэн майханг хүлээлгэж өгсөн юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-1	-6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,475	3,481
EUR	3,850	3,870
CNY	501	504
RUB	41.80	42.20
JPY	26.05	26.20
KRW	2.62	2.65

ЗУРХАЙ



2023.04.27 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 7

**ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР
ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ
ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.42-19.58

Барилдлага:

Хүчин төгсөх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
САНСАР

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдвэр үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдоно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 686,800,985

Эдгэрсэн

Нийт: 659,344,010

Нас барсан

Нийт: 6,861,784

Цахим шууданд

Ахлах дэслэгч Ц.Болдсайхан: ХАВРЫН ТАРИАЛАЛТ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАГДСАН



анги доторхи явган хүний болон автомашины зам, алба хаагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газар, сүүдрэвч, усан оргилуур гэх мэт тодорхой хэмжээний тохижилтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Мэдээж төсөл хэрэгжснээр алба хаагчдын ажиллах таатай орчин нөхцөл бүрдэнэ. Цөлжилт газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх болон агаарын бохирдлыг багасгах, элсний нүүдлийг зогсоох, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, цаг уурын таатай нөхцөлийг бүрдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Мод үржүүлгийн газруудын хаврын тариалалтын бэлтгэл ажил хэрхэн хангагдав. Хаана, хаана энэ төвүүд байгуулагдсан билээ?

-Зэвсэгт хүчний хэмжээнд таван Мод үржүүлгийн төв байгуулагдсанаас 4 нь Хуурай замын цэргийн нэгтгэл, ангийнх. Тухайлбал, Зэвсэгт хүчний 120 дугаар ангид 5 га, Зэвсэгт хүчний 186 дугаар ангид 3 га, Зэвсэгт хүчний 326 дугаар ангид 8 га талбайд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн 30 га талбайд "Эрдэнэс Тавантолгой" компанийн хөрөнгө оруулалтаар Мод үржүүлэг-Агропарк байгуулахаар төлөвлөлтийн шатандаа явагдаж байна. Мод үржүүлгийн төвүүд нь хаврын тариалалт хийх бэлтгэл ажлаа хангаад дууссан.

Ахмад Д.БОЛОР



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас харьяа нэгтгэл, ангиудын дунд "Хүний хөгжлийн эко, ногоон орчинг бүрдүүлье" уриатай болзолт уралдааныг 2022-2024 онд хоёр үе шаттайгаар зохион байгуулж байгаа билээ. Энэхүү төслийн явц, хэрэгжилтийн талаар Хуурай замын цэргийн командлалын Экологийн албаны дарга, ахлах дэслэгч Ц.Болдсайханаас тодрууллаа.

Командлалаас хэрэгжүүлж байгаа "Эко-Ногоон хотхон" төслийн явцын талаар мэдээлэл өгөхгүй юу? -Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командалаас "Эко-ногоон хотхон" төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнтэй уялдуулан хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд нэгтгэл, ангийн ойр тойрныг мод, бут тарих замаар зүлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээс гадна алба хаагчдад ая тухтай орчин бүрдүүлэх хүрээнд тохижилтын ажлуудыг давхар хэрэгжүүлж байна. Үүний нэг нь модон жорлонгоос татгалзаж, орчин үеийн нийтийн бие засах газар болгон шинэчлэх тухай асуудал юм. Зэвсэгт хүчний 167 дугаар ангид энэхүү ажил орон нутгийн хөрөнгө оруулалтаар анхлан хэрэгжихээр бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн автомашины зогсоол, зам талбайн гэрэлтүүлэг, цэргийн

Г.АЗЗАЯАГ "ГАВЬЯАНЫ АЛТАН ЗАГАЛМАЙ" ОДОНГООР ШАГНАЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дуда гэргийн хамт Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаа билээ.

Тэрээр өнөөдөр хоёр орны найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан зарим хүмүүсийг Польш Улсын Төрийн дээд шагналаар шагнасны дотор хошууч Г.Аззаяаг "Гавьяаны алтан загалмай" одонгоор шагналаа.

Хошууч Г.Аззаяа "Иракийн эрх чөлөө" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байх үедээ террорист халдлагыг нөхдийн хамтаар таслан зогсоож, олон үндэстний эвслийн цэргийн хүчний олон зуун цэргийн алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалж баатарлаг гавьяа байгуулсан юм.

ТҮВШИН ТОГТООХ ШАЛГАЛТЫГ ЯВУУЛЖ, ДҮНГЭЭ ГАРГАЛАА



аюулгүй байдлыг бүрэн хангаж оролцохыг чиглэл болгосон юм.

"Дүрэмч, жагсаалч байдал"-ыг жагсаалын үзлэг, алба, төв, хүн нэг бүрийн дүрэмч жагсаалч байдал, дүрэмт хувцасны үзлэгээр, онолын мэдлэгийг "Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд"-ийн хүрээнд боловсруулсан тестээр, ёс зүйн байдлыг "Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн хүрээнд боловсруулсан тестээр, "Сэтгэл зүйн байдал"-ыг дөрвөн төрлийн сорил, судалгаагаар, "Бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин"-г "Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-ын дагуу тогтоосон нормативаар тус тус явуулж дүнг гаргалаа.

Хошууч Ц.ЦЭВЭГДОРЖ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ 10 ЗӨВЛӨМЖ

- ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ
- ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР
- Ангийн онцлогт нийцсэн зааврыг боловсруулж, захиралчид танилцуулан батлуулах
- Осол, осолд дөхсөн тохиолдолд бүрт дүн шинжилгээ хийх
- Аюулыг илрүүлэх, мэдээлэх үйл явцыг зуршил болгох
- Жил бүр төсөв боловсруулан шийдвэрлүүлэх
- Хүн бүр хүлээсэн үүрэг, хариуцлагаа сахилга баттай биелүүлэх
- Дотоод хяналт шалгалтыг тогтмол хууруулах
- Албан тушаалтнуудын оролцоотойгоор эрдэлийн үнэлгээ хийх
- Сургалт, зааварчилгааны зохион байгуулалтыг тогтмол хэрэгжүүлэх
- Зөвлөл, комиссыг байгуулан үр дүнтэй ажиллуулах
- Тэргүүн туршлагыг судлах, түүнд дүн шинжилгээ хийх

ТАНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ - ТАНЫ ГАРТ

Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас зохион байгуулан явуулж буй цахим нөлөөллийн аяны хүрээнд дараах хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөмжийг хүргэж байна.

Нэгтгэл, анги, салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл (ажилтан)-үүд өдөр тутмын үйл ажиллагаандаа энэхүү зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг уриалж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

БАЙЛДАГЧ Г.ТӨГӨЛДӨР ОФИЦЕР, АХЛАГЧ НАРТАЙ ЭН ТЭНЦҮҮ ӨРСӨЛДӨЖ ШАГНАЛ ХҮРТЛЭЭ



талархал дэвшүүлээ.

Энэ үеэр олимпиадын тэргүүн болон тусгай байрын эздээс баярын сэтгэгдлийг нь хуваалцсан юм.

Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн ажиллагааны ахлах офицер, экологич, хошууч Ч.Гомбосүрэн:

-2013 онд ИБНАУ-д явагдаж байсан ажиллагаанд Монгол Улсын цэргийн багт буудагчаар үүрэг гүйцэтгэхдээ англи хэл сурах ёстой юм байна гэдэг зорилгыг өөртөө тавьсан. "Хэлтэй бол хөлтэй" гэдэг шиг гадаад хэлний мэдлэг хүний амьдралын энгийн хэрэгцээ болсныг ойлгож, ажиллагаанаас ирсэн даруйдаа ангийн удирдлагадаа хүсэлтээ өгч, 2014-2015 онд Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын төвд суралцаж байлаа. Дараа нь ИБНАУ-д дахин үүрэг гүйцэтгэхдээ орчуулагчаар, 2021 онд АНУ-ын Химийн офицерын анхан шатны дамжаанд суралцсан нь хэлний мэдлэгээ дээшлүүлэхэд түлхэц болж өгсөн.

Хэдийгээр би англи хэлийг анхлан сурсанаас хойш 8 жил өнгөрсөн ч гэсэн нэг ч өдөр орхиогүй. Зарим хүн суралцаж төгсчөөд хаячихдаг. Тэр маш буруу. Гадаад хэлийг уйгагүй, өөрийгөө голохгүй, шантрахгүй байж л сурч чадна. Тэгэхгүй бол амархан мартагдаж, замхарчихдаг гээд байдаг талтай. Өдөр бүр англи хэлээр мэдээ үзэх, унших, сонсох хэлбэрээр бие дааж суралцаж ирсэн минь өнөөдрийн амжилтыг авчирсанд баяртай байна.

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Г.Төгөлдөр:

-Офицер, ахлагч нартайгаа англи хэлний мэдлэгээ сорьж, тусгай байр зээлсэндээ баяртай байна. Энэ баярт мэдээг аав, ээждээ хуваалцана гэж бодохоос сайхан санагдаж байна. Миний хувьд хугацаат цэргийн албанд татагдаж ирэхээс өмнө АНУ-д эдийн засгийн чиглэлээр суралцаж байсан. Цэргийн зарлан гэрийн хаягаар маань ирсэн гэдгийг сонсоод сургуулиасаа чөлөө аваад эх орондоо ирж, өнөөдөр эр цэрэг болчихоод зогсож байгаа нь энэ.

Англи хэлийг би ердөө 11 дүгээр ангиасаа гүнзгийрүүлж суралцсан. Өмнө нь харилцааны түвшинд байсан бол хэлний мэдлэгээ илүү сайжруулах ёстой гэдэг шаардлагыг өөртөө тавьж, хичээнгүй суралцаж эхэлсэн. Ахлах ангийн сурагч байхдаа сургалт дамжаа болон бие даан сурч, үргэлжлүүлэн АНУ-д очоод хэрэглээ талдаа бага зэрэг сайжирсан гэж боддог. Цэргийн албанд ирээд ч англи хэл сурах сонирхлоо орхиогүй. Англи хэл дээрх ном, сонин уншиж, бичгийн чадвараа сайжруулахад нэгтгэлийн офицер, ахлагч нар үргэлж надад тусалдаг" гэсэн юм.

Ахмад Д.БОЛОР

Цэргийн алба хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, гадаадын сургууль, дамжаа, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр өөрийгөө бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас зохион байгуулсан "Англи хэлний олимпиад-2023" тэмцээний аваргууд өнөөдөр тодорлоо.

Олимпиадад Хуурай замын цэрэг болон Тусгай хүчний цэргийн зарим ангийн 20 гаруй офицер, ахлагч оролцсон бөгөөд тэдний дунд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Г.Төгөлдөр багтсан нь тэмцээн цол, мэргэжил харгалзахгүй явагдсаныг илтгэж байв. Цэргийн алба хаагчид унших, бичих, сонсох, орчуулах гэсэн дөрвөн төрлөөр өрсөлдсөнөөс унших, бичих чадварыг нь АНУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Батлан хамгаалахын атташегийн албатай хамтран зохион байгуулснаараа онцлог болов.

Ингээд тэмцээний тэргүүн байрт Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн ажиллагааны ахлах офицер, хошууч Ч.Гомбосүрэн, дэд байрт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн тагнуул, байр зүйн албаны дарга, хошууч Б.Жаргалсайхан, гутгаар байрт Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн артиллерийн дивизионы захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, ахмад Т.Лхагвабаатар, тусгай байрт Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн офицер, ахмад Б.Дүүрэнбаяр, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Г.Төгөлдөр нар шалгарч, шагналыг Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр гардуулан өглөө.

Тэрээр "Юуны өмнө олимпиадад оролцсон болон шалгарсан бүрэлдэхүүнд баяр хүргэе. Англи хэлийг төгс эзэмшинэ гэдэг таныг бусдаас нэг алхмын өмнө алхуулах зэвсэг болно. Өнөөдөр Зэвсэгт хүчний алба хаагчдын хэлний мэдлэг сайжирч байгаа ч илүү төгс эзэмших, олон гадаад хэл суралцах шаардлага бий. Тэр ч утгаараа энэхүү олимпиадыг цаашдаа уламжлал болгон зохион байгуулна" гээд офицер, ахлагчтай эн тэнцүү өрсөлдөж, тусгай байрт шалгарсан байлдагч Г.Төгөлдөрт